



Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Оюутны Холбоо

Гадаад Хэлний Сургуулийн
Оюутны Зөвлөлийн 10-р сарын ажлын тайлан

Тайланг дэмжсэн:

Оюутны Холбооны тэргүүн : / Ш. Өнөболд /

Тайланг хянасан:

Оюутны Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга : / Г. Ганчимэг /

Тайланг боловсруулсан:

Оюутны Зөвлөлийн нарийн бичиг: / Б. Гуамарал /

Энэ сард зохион байгуулагдсан үйл ажиллагаа:

1. “Намрийн тэргүүн 2022-2023” спортын бага наадам
2. “Элсэгчдийн аврага” шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн
3. “Урлагийн IX бага наадам”

1. “Намрийн тэргүүн 2022-2023” спортын бага наадам

“Намрын тэргүүн 2022-2023” спортын бага наадам 2022 оны 10 сарын 1-ний өдрөөс 8-ний өдөр хүртэл амжилттай зохион байгуулсан. Уг тэмцээн нь сагсан бөмбөг, волейбол, шатар, даам гэсэн 4 төрлөөр зохион байгуулагдсан ба сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй, эмэгтэй, волейбол-ийн төрөлд холимог гэсэн төрлүүдэд хуваагдан зохион байгуулагдсан. Нээлтийн үйл ажиллагаа 2022 оны 10 сарын 8-ний өдөр зохион байгуулагдаж, Чанар Сургалтын Албаны дарга А. Болормаа болон Оюутны Зөвлөлийн дарга Б. Бадамгарав, Оюутны Зөвлөлийн дэд дарга М. Анужин нар нээлтийн үг хэлж нээсэн. Тус тэмцээнд ТТО-Англи хэл 1, ТТО-Англи хэл 2,3, ТТО-Англи хэл 4, ТТО-Хятад хэл 1, ТТО-Хятад хэл 2,5, Солонгос хэл, Япон хэл 1, Япон хэл 2, Инженерийн бэлтгэл гэсэн 9 баг тамирчид оролцсон. 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдөр шатар, даамны тэмцээнийг зохион байгуулж, шатрын төрөлд ТТО-Англи хэл 1 нэгдүгээр байр, ТТО-Япон хэл 2 хоёрдугаар байр, инженерийн бэлтгэл гуравдугаар байр, даамны төрөлд ТТО-Англи хэл 1 нэгдүгээр байр, ТТО-Солонгос хэл хоёрдугаар байр, ТТО-Хятад хэл 2,5 гуравдугаар байрыг тус тус эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Мөн оны 10 дугаар сарын 8-ний өдөр сагсан бөмбөг болон волейбол-ийн төрлийг зохион байгуулж, эрэгтэй сагсан бөмбөгийн төрөлд ТТО-Хятад хэл 2,5 нэгдүгээр байр, ТТО-Хятад хэл 1 хоёрдугаар байр, ТТО-Англи хэл 1 гуравдугаар байр эзэлсэн бөгөөд эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд ТТО-Англи хэл 2 нэгдүгээр байр ТТО-Англи хэл 4 хоёрдугаар байр, ТТО-Япон хэл 1 гуравдугаар байрыг эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Холимог волейбол-ийн төрөлд ТТО-Англи хэл 2,3 нэгдүгээр байр, ТТО-Солонгос хэл хоёрдугаар байр, ТТО-Хятад хэл 2,5 гуравдугаар байрыг тус тус эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан.



Зураг 1. Нээлтийн үйл ажиллагааны үеэр

“Намрын тэргүүн 2022-2023” спортын бага наадамд оролцсон багуудын нийт оноогоор ТТО-Англи хэл нэгдүгээр байр, ТТО-Солонгос хэл хоёрдугаар байр, ТТО-Хятад хэл гуравдугаар байр тус тус эзэлж ТТО-Англи хэл шилдэг ангиар шалгарч шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналыг гардан авсан. Тус спортын бага наадмын шилдэг тоглогчоор эрэгтэй сагсан бөмбөгийн төрөлд ТТО-Англи хэл 1 Саян, эмэгтэй сагсан бөмбөгийн төрөлд ТТО-Англи хэл 2 Дуламдорж, волейбол-ийн төрөлд эрэгтэй шилдэг тоглогчоор ТТО-Солонгос хэл 2 Дэчинжамц, волейбол-ийн төрөлд эмэгтэй шилдэг тоглогчоор ТТО-Англи хэл 2 Мишээлт-Од нар шалгарсан.



Зураг 2. Шилдэг анги

2. Элсэгчдийн аварга шалгаруулах тэмцээн

2022 оны “Элсэгчдийн аварга” шалгаруулах тэмцээн 10 сарын 20-ний өдрөөс 22-ний өдөр хүртэл Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн төв спорт зааланд зохион байгуулагдсан. Уг тэмцээн шинээр элсэн орсон оюутнуудын дунд зохион байгуулагддаг сагсан бөмбөгийн тэмцээн юм. Тус тэмцээнд Гадаад Хэлний Сургууль, Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль нэгдэн орсон бөгөөд эрэгтэй сагс болон эмэгтэй сагсны төрөлд 2 баг тамирчид оруулсан.



Зураг 2. Нээлтийн үйл ажиллагааны үеэр

3. “Урлагийн IX бага наадам”

Гадаад Хэлний Сургуулийн “Урлагийн IX бага наадам” 2022 оны 10 сарын 29-ны өдөр зохион байгуулагдсан. Тус тэмцээний зорилго нь оюутнуудын авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, гоо зүйн мэдрэмж ёс суртахууны хүмүүжлийг урлагаар дамжуулан олгох, цаашлан хот, улсын чанартай тэмцээнд оролцуулах, сургуулиа сурталчлах, сургуулийн нэр хүндийг өндөрт өргөхөд оршино. Уг тэмцээн гоцлол дуу, гоцлол бүжиг, гоцлол хөгжим, уран уншлага, хамтлаг бүжиг, хамтлаг дуу, жүжигчилсэн тоглолт гэсэн 7 төрлөөр зохион байгуулагдсан. Гоцлол дууны төрөлд ТТО-Англи Г. Оюунханд нэгдүгээр байр, ТТО-Хятад Б. Сүнжидмаа гуравдугаар байр эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Гоцлол бүжгийн төрөлд ТТО-Япон М. Мөнхсар нэгдүгээр байр, ТТО-Хятад Г. Лхагвамаа гуравдугаар байр эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Гоцлол хөгжмийн төрөлд Япон Т. Энэрэл хоёрдугаар байр эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Уран уншлагын төрөлд ТТО-Англи Э. Дагийранз хоёрдугаар байр, ТТО-Хятад Д. Мөнхчулуун гуравдугаар байр эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Хамтлаг дууны төрөлд ТТО-Англи нэгдүгээр байр, Япон хоёрдугаар байр, ТТО-Хятад гуравдугаар байр тус тус эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Хамтлаг бүжгийн төрөлд Япон нэгдүгээр байр, ТТО-Хятад хоёрдугаар байр, ТТО-Англи гуравдугаар байр эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. Жүжигчилсэн тоглолтын төрөлд ТТО-Англи нэгдүгээр байр, ТТО-Хятад хоёрдугаар байр эзэлж медаль, өргөмжлөл гардан авсан. “Урлагийн IX бага наадам”-д оролцсон багуудын нийт оноогоор ТТО-Хятад нэгдүгээр байр, Япон хоёрдугаар байр эзэлж, ТТО-Хятад шилдэг ангиар шалгаран шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналыг гардан авсан.



Зураг 3. Шилдэг анги

Батлав:

ГХС-ийн Чанар Сургалтын Албаны дарга:/А. Болормаа/

Гадаад Хэлний Сургуулийн Оюутны зөвлөлийн ажлын үзүүлэлт

2022 оны 9-р сар

№	Үзүүлэлтүүд	Сард авбал Зохих хувь	Нийт	Тайлбар
1	Зохион байгуулсан ажлын үр дүн	50%		
2	ШУТИС-ийн нэгдсэн зохион байгуулалттай ажлын үр дүн	20%		
3	Өгсөн үүрэг даалгаврын биелэлт	20%		
4	Хурлын ирц, хурлын дэг, удирдах зөвлөлийн гишүүний ёс зүйн үүрэг хариуцлага	10%		
5	Нийт	100%		
6	Олгох хувь			

Тайланг дэмжсэн:

Оюутны Холбооны тэргүүн:

/ Ш.Өнөболд /

Тайланг хянасан:

Оюутны Холбооны ерөнхий нарийн бичгийн дарга:

/ Г. Ганчимэг /

Тайланг боловсруулсан:

Оюутны Зөвлөлийн нарийн бичиг:

/ Б. Гуамарал /